



БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХЖИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *М.Мөнхөө*



БАТЛАВ
АЛСЫН ӨГӨӨЖ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *Б.Чинбат*

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2023 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 2023/105

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нөгөө талаас Алсын өгөөж ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Чинбат /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1 Гэрээний зорилго нь “Авто хүнд машин механизмын хэсгийн ахуйн байрны бохирын шугам хоолой, худаг засварлах” ажлуудыг дор дурдсан хугацаанд гүйцэтгэж захиалагч талд хэвийн үйл ажиллагааг ханган хүлээлгэж өгөх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын тайланг үндэслэн, гүйцэтгэлийг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хүлээх, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний нөхцөл, ерөнхий зүйл

- 2.1 Гүйцэтгэгч нь “Авто хүнд машин механизмын хэсгийн ахуйн байрны бохирын шугам хоолой, худаг засварлах” (цаашид “ажил” гэх) -ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заагдсан хугацаанд багтаан хийж гүйцэтгэнэ.
- 2.2 Ажил гүйцэтгэх хугацаа гэрээ байгуулагдсан өдрөөс 30 хоног байна.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ 18,000,000 /арван найман сая/ төгрөг бөгөөд үнийн дүнд бараа материал, угралт суурьлуулалт, засвар үйлчилгээний хөлс багтсан болно.
- 3.2 Захиалагчаас гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.3 Ажил хүлээлгэн өгсний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 15 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу гүйцэтгэгчийн Хаан банкны 5085769232 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 4.1 Гэрээт ажлыг ажил гүйцэтгэх гэрээний баримт бичигт заагдсан эзлэхүүний дагуу, гэрээнд заагдсан үнэд багтаан батлагдсан хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.
- 4.2 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг бүрэн хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч байгууллагын шаардлагаар ажлыг зогсооно.

Захиалагч:

М.Мөнхөө

1/4

Гүйцэтгэгч:

Б.Чинбат

- 4.3 Ажил гүйцэтгэх хугацаанд Эрчим хүчний системд мөрдөж буй Техник Ашиглалтын Дүрэм, Аюулгүй Ажиллагааны Дүрэм болон холбогдох бусад дүрэм журмын мөрдөж ажиллана. Захиалагчийн тавьсан шаардлага зөвлөмжийг заавал биелүүлнэ.
- 4.4 Гүйцэтгэгч тал захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй
- 4.5 Ажлыг гүйцэтгэгч компани нь уг ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрдөнө.

Тав: Захиалагчийн эрх, үүрэг

- 5.1 Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд нь ажлын комисс хүлээн авна.
- 5.2 Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд захиалагч талаас хяналтыг тогтмол тавьж ажиллана.
- 5.3 Захиалагч талаас гэрээний үнийн дүнг өөрчлөхгүйгээр нэмэлт ажил, ажлын тоо хэмжээнд гүйцэтгэгчтэй тохиролцсоны үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

- 6.1 Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.2 Захиалагч нь ажлын гүйцэтгэл, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.3 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Механик инженер Н.Сайнбилэг хариуцан ажиллана утас-98099919, Барилга, сантехник, дулаан хангамжийн инженер Б.Адарсүрэн утас-99810004 нар хариуцан ажиллана.
- 6.4 Гүйцэтгэгчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Захирал Б.Чинбат хариуцан ажиллана. Утас-99062110.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцөлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцөлүүд хэсэгчлэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.
- 7.3 Давагдашгүй хүчин зүйл гэдгийг зөвхөн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим батална.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1 Гүйцэтгэгч нь ажлыг энэхүү гэрээний 2.1-т заасан хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид албан ёсоор бичгээр өгнө. Гүйцэтгэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцална.
- 8.2 Гүйцэтгэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

Захиалагч:



2/4

Гүйцэтгэгч:



- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Гүйцэтгэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Э.МӨНХЖАРГАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

 Ө.УДВАЛ


АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Г.БАТТУЛГА

ХУУЛИЙН
МЭРГЭЖИЛТЭН

 Г.САРУУЛ

БАРИЛГА, САНТЕХНИК
ДУЛААН ХАНГАМЖИЙН ИНЖЕНЕР

 Б.АДАРСҮРЭН

МЕХАНИК ИНЖЕНЕР

 Н.САЙНБИЛЭГ

ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН

 М.МОЛОМЖАВ

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЛСЫН ӨГӨӨЖ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ



Б.ЧИНБАТ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

Хаяг: Монгол улс, Хан-Уул дүүрэг 02-р хороо 89А байр
100 тоот
Утасны дугаар: 77114990, 99558849
РД: 5367166.

Захиалагч:



3/4

Гүйцэтгэгч:

